ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДУА-2026/15/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дундговь аймаг<br>2026 он | Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Батсайхан<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Ж.Угтахбаяр<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn<br><br>Аудитор: Д.Должинсүрэн<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 5

3. Аудитын илрүүлэлт .......... 7

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал ... 7

**3.2 Зөвлөмж** .......... 8

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .......... 10

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2026.03.23 № 83

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.МӨНХБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 147.9 сая төгрөгөөр өссөн байна.

Эрдэнэдалай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 12 дугаар тогтоолоор тайлант онд 1,296,728.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,256,440.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 96.9 хувиар биелүүлж, 40,287.5 мянган төгрөгөөр орлого тасарсан байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний

4826050279

эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 274.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 112 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 94.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

| Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| 1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,805,038.9 | 2,414,923.3 |
| 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 616,841.8 | 952,849.2 |
| 1.1.3 АВЛАГА | 753,204.8 | 926,330.4 |
| 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 274,792.3 | 357,543.6 |
| 1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 160,200.0 | 178,200.0 |
| 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,003,489.8 | 5,099,473.6 |
| 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,003,489.8 | 5,099,473.6 |
| 1.2.2.02 Биет хөрөнгө | 4,942,411.2 | 5,040,282.9 |
| 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 61,078.6 | 59,190.7 |
| 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 6,808,528.7 | 7,514,396.9 |
| 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,020,703.4 | 2,295,074.2 |
| 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 80,875.1 | 355,245.9 |
| 2.1.1.03 Өглөг | 80,875.1 | 355,245.9 |
| 2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,939,828.2 | 1,939,828.2 |
| 2.1.2.02 Урт хугацаат зээл | 1,939,828.2 | 1,939,828.2 |
| 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,787,825.3 | 5,219,322.7 |
| 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 4,787,825.3 | 5,219,322.7 |
| 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 855,826.9 | 855,826.9 |
| 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 3,267,260.1 | 3,698,757.5 |
| 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 664,738.4 | 664,738.4 |
| 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 6,808,528.7 | 7,514,396.9 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

| Дансны нэр, төрөл | 5. Өмнөх он | 6. Тайлант он |
|---|---|---|
| 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 4,540,241.7 | 4,117,841.5 |
| 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 1,305,414.6 | 1,256,440.5 |
| 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 886,709.2 | 858,576.5 |
| 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 886,709.2 | 858,576.5 |
| 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 218,353.7 | 223,693.4 |
| 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 200,351.7 | 174,170.7 |
| 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 801,151.6 | 2,861,401.0 |
| 1.1.1.04.3 Тусламжийн орлого | - | 1,758,222.6 |
| 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,433,675.5 | - |
| 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,999,039.3 | 3,495,415.9 |
| 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 2,999,039.3 | 3,495,415.9 |
| 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,949,292.6 | 3,369,022.9 |
| 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 857,891.2 | 1,005,799.1 |
| 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,603.7 | 125,263.3 |
| 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 769,180.4 | 831,335.3 |
| 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 107,499.7 | 238,549.2 |
| 1.1.2.01.1.05 Нормативт зардал | 4,050.0 | 8,589.1 |
| 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 70,799.7 | 78,757.2 |
| 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 23,542.0 | 26,079.4 |
| 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 222,129.3 | 225,272.4 |
| 1.1.2.01.1.0 Бараа үйлчилгээний бусад зардал | 787,596.7 | 829,378.0 |
| 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,746.7 | 126,392.9 |
| 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 1,541,202.4 | 622,425.6 |

| | | |
|---|---|---|
| 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,161,725.6 | 209,992.0 |
| 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | (1,161,725.6) | (209,992.0) |
| 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 379,476.7 | 412,433.6 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

| Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/ өмч |
|---|---|---|
| 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,331,348.6 | 4,331,348.6 |
| 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 77,000.0 | 77,000.0 |
| 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,408,348.6 | 4,408,348.6 |
| 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 379,476.7 | 379,476.7 |
| 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,787,825.3 | 4,787,825.3 |
| 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,787,825.3 | 4,787,825.3 |
| 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 19,063.7 | 19,063.7 |
| 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,806,889.1 | 4,806,889.1 |
| 1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 73.8 | 73.8 |
| 1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | ( 73.8) | (73.8) |
| 1.7 Тайлант үеийн үр дүн | 412,433.6 | 412,433.6 |
| 1 2025 оны 12-р сарын 31-наарх | 5,219,322.7 | 5,219,322.7 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,850,504.2 | 3,810,802.2 |
| 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 1,305,414.6 | 1,256,440.5 |
| 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 886,709.2 | 858,576.5 |
| 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 218,353.7 | 223,693.4 |
| 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 200,351.7 | 174,170.7 |
| 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 17,051.5 | 10,849.9 |
| 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 58,020.2 | 79,800.8 |
| 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 125,280.0 | 83,520.0 |
| 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 111,414.2 | 2,554,361.7 |
| 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 111,414.2 | 112,906.9 |
| 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | - | 1,761,533.7 |
| 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 679,921.2 |
| 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,519,565.2 | 2,677,958.0 |
| 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 2,519,565.2 | 2,677,958.0 |
| 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,469,818.5 | 2,544,392.1 |
| 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 860,158.2 | 1,005,681.2 |
| 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,571.3 | 124,624.4 |
| 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 768,856.4 | 835,670.3 |
| 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 92,737.0 | 66,744.8 |
| 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 5,070.0 | 6,272.8 |
| 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 71,143.6 | 66,597.0 |
| 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 23,542.0 | 18,336.4 |
| 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 222,856.5 | 225,102.5 |
| 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 318,883.6 | 195,362.9 |
| 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,746.7 | 133,565.9 |
| 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 1,330,939.0 | 1,132,844.2 |
| 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 983,150.9 | 796,836.8 |
| 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 983,150.9 | 796,836.8 |
| 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 983,150.9 | 796,836.8 |
| 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (983,150.9) | (796,836.8) |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 347,788.1 | 336,007.4 |
| 1.2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 269,053.8 | 616,841.8 |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 616,841.8 | 952,849.2 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

| Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 4,323,474.2 | 3,455,048.6 |
| Татварын орлого | 1,346,728.0 | 1,256,440.5 |
| Татварын бус орлого | 2,976,746.2 | 2,198,608.1 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,323,474.2 | 3,114,995.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,737,008.0 | 2,318,456.6 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,600,866.5 | 2,192,063.6 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 971,977.9 | 894,673.2 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 120,747.2 | 111,279.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 875,178.7 | 830,580.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 101,356.6 | 59,736.9 |
| Нормативт зардал | 2,227.0 | 2,227.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 90,251.0 | 66,597.0 |
| Томилолт, зочны зардал | 29,487.4 | 18,336.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 136,786.6 | 58,145.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 272,854.1 | 150,487.9 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 136,141.5 | 126,392.9 |
| Бусад урсгал шилжүүлэг | 136,141.5 | 126,392.9 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,334,766.2 | 796,538.8 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 612,614.8 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 952,668.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 355,753.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 355,753.7 |
| 122 | Тусламжийн орлого | 355,753.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 348,580.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 348,580.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 348,580.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 111,008.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,344.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,090.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,007.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 167,255.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,875.0 |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - 7,172.9 |

### 3. Аудитын илрүүлэлт

### 3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 40,287.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 40,287.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүллээ.

***Залруулаагүй алдаа:***

Аудитаар нийт 40,287.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Сумын татварын орлого 40,287.5 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2.-д (батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих), Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д (нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах) мөн нийцсэн батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 3.3 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | **5** | | **1** | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 12,937.6 мянган төгрөгийн алдаа, 455,173.2 мянган төгрөгийн зөрчил нийт 468,110.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс 37,934.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 417,239.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлжээ.

Аудитаар илрүүлсэн зөрчлийн 97.6 хувь буюу 456,830.6 мянган төгрөгийг нийцлийн асуудал, 2.4 хувь буюу 11,280.2 хувийг санхүүгийн асуудал эзэлж байна. Аудитын дүгнэлтэд нөлөөлөх санхүүгийн асуудал нь тооцсон материаллаг түвшингээс 3 дахин бага тул нэгтгэсэн санхүүгийн тайланд “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 12,683.6 | 1 | 12,683.6 | | | 1 | 12,683.6 | | | | |
| ХХС | 1 | 254.0 | | | 1 | 254.0 | 1 | 254.0 | | | | |
| Дүн | **2** | **12,937.6** | **1** | **12,683.6** | **1** | **254.0** | **2** | **12,937.6** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 3 | 9,588.2 | | | 3 | 9,588.2 | | | | | | |
| ИТХ | 1 | 900.0 | | | 1 | 900.0 | | | | | | |
| ОНХС | 1 | 792.0 | | | 1 | 792.0 | | | | | | |
| **Нийт дүн** | **5** | **11,280.2** | | | **5** | **11,280.2** | | | | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 204,782.1 | | | | | 1 | 204,782.1 | | | | |
| ИТХ | 1 | 26,653.9 | | | 1 | 26,653.9 | | | | | | |
| ОНХС | 1 | 172,169.5 | | | 1 | 172,169.5 | | - | | | | |
| ТТЗ | 1 | 40,287.5 | | | | | 1 | 40,287.5 | | | | |
| **Нийт дүн** | **4** | **443,892.9** | | | **2** | **198,823.4** | **2** | **245,069.6** | | | | |